



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/14

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар журам, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын А/03 дугаар журмуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Замын сангийн хөрөнгө оруулалтаар Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай замтай Хөшөөтийн уурхайг холбох зураг төсвийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Н.Эрдэнэцэцэг	- Худалдан авах ажиллагааны албаны ахлах мэргэжилтэн
Гишүүдэд:	Б.Барсболд	- 6 дугаар сургуулийн захирал
	Б.Ганзориг	- Төрийн бус байгууллагын төлөөлөл
	Ю.Ганбат	- Иргэний төлөөлөл
Нарийн бичиг:	Э.Цолмон	- Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (Н.Эрдэнэцэцэг)-д даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (Э.Цолмон)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБӨЛД

8400 03 0069

D/Tush-A/14-Bo